

**ОЛОН УЛСЫН АГААРЫН ТЭЭВЭРЛЭГЧДИЙН ХОЛБОО (IATA)-НЫ  
ХОЙД АЗИЙН БҮС НУТАГ ХАРИУЦСАН ДЭД ЕРӨНХИЙЛӨГЧ ШИЕ  
ШИНЧИАНТАЙ ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ЯАМНЫ ТӨРИЙН НАРИЙН  
БИЧГИЙН ДАРГА БЭЭЖИН ХОТОД БАЙРЛАХ ХОЙД АЗИЙН БҮС НУТГИЙН  
ОФФИС ДЭЭР ХИЙХ УУЛЗАЛТАД ОРОЛЦСОН ТАЛААРХ ТАЙЛАН**

2024.02.07

1. Олон улсын агаарын тээвэрлэгчийн холбоо (IATA)-ны Хойд Азийн бүс нутаг хариуцсан дэд ерөнхийлөгч Шие Шинчиантай агаарын тээврийн салбарт Монгол Улстай цаашдын хамтын ажиллагааг өргөжүүлэх, Монгол Улс болон бүс нутагт тулгамдаж буй асуудлуудаар Монгол Улсын Зам, тээврийн хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Батболдтой хийх уулзалтад 2024 оны 01 дүгээр сарын 12-ны өдрийн А/ЗЗ дугаар тушаалаар баталсан удирдамжийн дагуу Иргэний нисэхийн үндэсний төвийн харьяа “Буянт-Ухаа” Олон улсын нисэх буудлын дарга Л.Отгонжаргал, Иргэний нисэхийн үндэсний төвийн харьяа “Ховд” нисэх буудлын дарга Б.Болорцэцэг, Бодлогын хэрэгжилтийн хэлтсийн төлөвлөлт хариуцсан ахлах мэргэжилтэн Б.Энх-Амгалан, Гадаад хамтын ажиллагааны хэлтсийн эдийн засгийн зохицуулалтын мэргэжилтэн У.Энхриймаа нар оролцов.

Монголын агаарын тээврийн салбарт тулгамдаж буй асуудлуудыг шийдвэрлэхийн тулд аюулгүй байдал, үйл ажиллагаа болон тогтвортой хөгжлийн чиглэлээр IATA-ны зүгээс авч болох дэмжлэг, Монгол Улсын Зам, тээврийн хөгжлийн яам болон IATA-ны зүгээс олон улсын болон бүс нутгийн уулзалт, хурал зохион байгуулах замаар хамтын ажиллагаагаа идэвхжүүлэх болон бусад асуудлаар хэлэлцэж, санал солилцов. Үүнд:

- Иргэний нисэхийн салбарын гадаад дахь сургалтын асуудлыг шийдвэрлэх ажлын хүрээнд IATA-ны сургалтын төвийг “Буянт-Ухаа” Олон улсын нисэх буудалд байгуулах талаар;
  - IATA болон ИНЕГ-ын хооронд байгуулсан Санамж бичгийн хүрээнд зохион байгуулах ажлууд, цаашид хамтран зохион байгуулах олон улсын хурал, хэлэлцүүлгийн талаар;
  - Орон нутгийн зарим нисэх онгоцны буудлуудын хүчин чадлыг нэмэгдүүлэх, концессоор шилжүүлэх асуудлаар IATA-ны зөвлөх үйлчилгээ авах талаар;
  - Агаарын навигацийн хураамжийг шинэчлэх, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах талаар;
  - Цээл агаарын хаалгыг нээхтэй холбогдуулан IATA-оос дэмжлэг үзүүлэх, БНХАУ-ын холбогдох удирдлага/захиргааны байгууллагатай энэ асуудлаар ярилцах талаар;
2. БНХАУ-ын Бээжингийн нисэх, сансар судлалын их сургуультай хамтран ажиллах тухай уулзалтыг 2024 оны 01 дүгээр сарын 26-ны өдөр зохион байгуулсан.

Тус уулзалтаар Зам, тээврийн хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Батболд Бээжингийн нисэх, сансар судлалын их сургуулийн дэд захирал Жао Вей Шен нар БНХАУ-ын нийслэл Бээжин хотноо

уулзаж, нисэхийн салбарын хүний нөөцийг бэлтгэх чиглэлээр хамтран ажиллах тухай санамж бичигт гарын үсэг зурсан.

#### Төмилөлтын үр дүн

1. “Буянт-Ухаа” олон улсын нисэх буудалд IATA-ны сургалтын төвийг байгуулах талаар санал солилцож, тус сургалтын төвийг нээх талаар товч танилцуулгыг IATA-ны талаас хийсэн. Тус танилцуулгын дагуу IATA нэмэлт мэдээллийг Монголын талд ирүүлэхээ мэдэгдсэн бөгөөд IATA-оос гэрчилгээжсэн сургалтын төвийг байгуулахад 3 сар болдог тул ойрын хугацаанд тус сургалтын төвийг “Буянт-Ухаа” олон улсын нисэх буудал болон “МИАТ” ТӨХК-ний сургалтын төвд байгуулах боломжтой болохыг илэрхийлсэн.
2. IATA болон ИНЕГ-ын хооронд байгуулсан Санамж бичгийн хүрээнд IATA-ны зүгээс Монгол Улсад 2024 оны эхний хагаст IOSA аудит шалгалтын талаар агаарын тээвэрлэгчид болон хяналт, зохицуулалтын байгууллагыг хамарсан семинар зохион байгуулах хүсэлт тавьсан. Тус семинар нь нислэгийн аюулгүй ажиллагааны хяналт, зохицуулалтыг дэмжих, эрсдэлд суурилсан IOSA аудит, шалгалтыг хэрэгжүүлэх зэрэг асуудлуудаар зохион байгуулагдах бөгөөд нарийвчилсан төлөвлөгөөг IATA-оос ирүүлэхээр болсон.
3. Агаарын навигацийн хураамжийг шинэчлэх асуудлаар IATA-ны талаас 2024 оны эхний улиралд агаарын тээвэрлэгчидтэй уулзалт зохион байгуулах санал тавьсан. Уулзалтыг агаарын навигацийн хураамж шинэчлэгдэхээс 4 сарын өмнө зохион байгуулах шаардлагатай болохыг IATA мөн илэрхийлсэн. Тус уулзалтын талаар нарийн төлөвлөгөөг IATA-оос ИНЕГ-т ирүүлэхээр тохирсон.
4. “Ховд” нисэх буудлыг хөгжүүлэх, олон улсын статустай болгох, Концессын гэрээгээр шилжүүлэхэд хувийн хэвшилд тааламжтай болгох зорилгоор IATA-оос зөвлөх үйлчилгээ авах хүсэлтийг Монголын талаас тавьсан.  
IATA-ын талаас зөвлөх үйлчилгээ үзүүлэхэд бэлэн байгаагаа илэрхийлсэн бөгөөд “Ховд” нисэх буудлын талаар нэмэлт мэдээлэл ирүүлэх, мөн Монгол талаас ирүүлсэн мэдээллийн дагуу IATA зөвлөх үйлчилгээний төслийг бэлдэж, Монгол талын хүсэлтийн дагуу Зам, тээврийн хөгжлийн сайдын 2024 оны 04 дүгээр сард БНХАУ-д хийх айлчлалын үеэр зөвлөх үйлчилгээний гэрээг зурахад бэлэн болгохоор тохирсон.
5. БНХАУ-тай шинээр “Цээл” агаарын хаалгыг нээх ажлыг 2022 оноос одоог хүртэл шийдвэрлэхээр ажиллаж байгаа, түүнчлэн тус агаарын хаалга нээгдсэнээр агаарын тээвэрлэгч нарт ямар давуу тал үүсэх тухай хэлэлцсэн бөгөөд тус асуудалд IATA-оос БНХАУ-ын холбогдох удирдлага/захиргааны байгууллагатай тухайн асуудлаар ярилцаж, дэмжлэг үзүүлэхээ IATA-оос илэрхийлсэн.
6. Монгол Улсад олон улсын хурал, уулзалт хамтран зохион байгуулах талаар санал солилцож, IATA-ны талаас төв Азийн орнуудыг хамарсан олон улсын уулзалт Монгол Улстай хамтран зохион байгуулах сонирхолтой байгаагаа илэрхийлсэн.

7. БНХАУ-ын Бээжингийн нисэх, сансар судлалын их сургуультай санамж бичгийг байгуулснаар Монгол Улсын зам, тээврийн салбар, тэр дундаа нисэхийн чиглэлийн боловсон хүчин бэлтгэх, бакалавр, магистр, докторын зэрэгт суралцах боломж бүрдэж байна.

Санамж бичгийн хүрээнд эхний ээлжид Монгол талаас 60 оюутан тус сургуульд суралцуулах боломжтой болсон бөгөөд цаашид идэвхтэй хамтран ажиллах, тэтгэлэгт хамруулах тухай тохиролцсон.

ТАНИЛЦСАН:  
БХХ-ИЙН ДАРГА

Ч.ОДГЭРЭЛ

ГХАХ-ИЙН ДАРГА

Г.БАТБАЯР

ТАЙЛАН БИЧСЭН:  
ГХАХ-ИЙН МЭРГЭЖИЛТЭН

*У.Энхриймаа*

У.ЭНХРИЙМАА